

БАГШ ОЮУТНЫ ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Л.Мөнхчулуун¹, Д.Хишигжаргал¹, Ш.Оюунчимэг¹

¹АШУУИС, Дархан-Уул аймаг дахь АУС

munkhchuluun@mnums.edu.mn

Удирдагч: Д.Алтайхүү (PhD)

Хураангуй

Багш хүн мэдлэгтэй чадвартай байхын зэрэгцээ суралцагчдыг ойлгогдог, сурахын төдийгүй сургахын арга ухаанд суралцсан байх шаардлага нь багш оюутны харилцааг сайжруулахад тодруулбал багшийн харилцаа, арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд чухал нөлөө үзүүлж байгаагаар илэрч байна.

Тиймээс бид багшийн оюутнуудын харилцаатай холбоотой онолын судалгааны ажлуудыг уншиж судлан улмаар багшийн харилцаа, арга зүйн талаар өөрийн сургуулийн суралцагчдаас судалгаа авч, судалгааны үр дүнд боловсруулалт хийж, дүгнэлт гаргахыг зорилгоо.

Тус судалгаа нь багшийн оюутнуудтай харилцдаг харилцаа, багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутны сурах хүсэлд хэрхэн нөлөөлж байгаад дүгнэлт хийхийн зэрэгцээ оюутнуудын хөгжил төлөвшилд нөлөөлөх багшийн хувийн зан чанарын талаар анхаарах шаардлага байгааг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Сурах хүсэл, сургахуйн арга зүй, хувийн зан чанар, нөлөөлөл,

Удиртгал

Энэхүү судалгаанд оюутнуудын үр дүнтэй, амжилттай суралцах, өнөөдрийн өдөр тутам тулгарч буй бэрхшээлийг даван туулахад багш оюутнуудын хоорондын харилцаа хэрхэн нөлөөлж буй байдал, тэр эерэг харилцааны нөлөөллийн талаарх асуудлуудыг хамрууллаа.

Хүн эхээс төрсөн цагаас эхлэн харилцаанд оролцдог бөгөөд "Харилцаа нь бид бусдыг, бусад хүмүүс биднийг ойлгоход ашиглагддаг үйл явц" (Anderson, J.A.1996) учраас тэрээр үгэн ба үгэн бус хэлбэрээр, зориудын ба зориудын бус замаар бусдад ойлгогдож, хүргэгдэж байгаа мэдээлэл түүний боловсруулалт, үр дүн юм.

Иймээс багш хүн сургалтын үйл явцдаа оюутнуудтайгаа эерэг харилцааг бий болгосоноор оюутнууд амжилттай суралцахад хэрхэн нөлөөлж

буй байдал, түүний үр дүнг судлах шаардлага нь тус судалгааны ажлын ач холбогдлыг тодорхойлно гэж үзэж байна.

Зорилго: Дархан-Уул аймаг дахь АУС-ийн багш оюутнуудын хоорондын харилцааны талаар асуумж судалгаа авч, улмаар үр дүнд боловсруулалт, үнэлэлт, дүгнэлт өгөх

Зорилт:

- Багш оюутнуудын хоорондын харилцааны талаар судалгааг авах
- Судалгааны үр дүнд боловсруулалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх

Материал арга зүй:

Судалгаанд Дархан-Уул аймаг дахь АУС-ийн I, II, III, IV дамжааны 100 оюутан хамрагдсан. Судалгааг асуумж, анкет, анализ, харьцуулалтын аргаар хийв. Судалгааны ажлын үр дүнг Microsoft office - 2016, статистик боловсруулалтыг SPSS - 20.0 програмыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Судалгааны үр дүн:

Дархан-Уул аймаг дахь АУС-ийн багш оюутны харилцааг тодруулах зорилгоор дараах асуумжийг авсан бөгөөд багш оюутан бүрийг хувь хүний хувьд хүндэлдэг нь 77%, хааяа 15%, багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд 82% нь нөлөөлдөг, нөлөөлдөггүй гэдэгт 13%, багш таныг сонсож чаддаг гэдэгт 75%, хааяа сонсдоггүй гэдэгт 22%, багш хичээлийн орон зайн хэмжээг 73% баримталдаг, хааяа баримталдаггүй гэдэгт 24%, багш оюутнуудтай найрсаг харилцааг бий болгодог гэдэгт 47%, заримдаа найрсаг биш харилцаа нь 29% тус тус хариулсан (Хүснэгт 1) байна.

Хүснэгт 1


№	Асуумж	Нийт	Дамжаа			
			1-р	2-р	3-р	4-р
1	Багш оюутан бүрийг хувь хүний хувьд хүндэлдэг үү					
	Тийм	77(77.0)	26(100.0)	22(88.0)	18(69.2)	11(42.3)
	Үгүй	8(8.0)	0(0.0)	1(4.0)	6(23.1)	1(3.8)
	Хааяа	15(15.0)	0(0.0)	2(8.0)	2(7.3)	11(42.3)
2	Багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд нөлөөлдөг үү					
	Тийм	82(82.0)	25(96.2)	22(88.0)	16(61.5)	19(73.1)
	Үгүй	13(13.0)	0(0.0)	3(12.0)	6(23.1)	4(15.4)
	Мэдэхгүй	5(5.0)	1(1.8)	0(0.0)	4(15.4)	0(0.0)

3	Багш оюутнуудтай найрсаг харилцааг бий болгодог уу				
Тийм	47(47.0)	15(57.7)	12(48.0)	15(57.7)	5(19.2)
Үгүй	24(24.0)	0(0.0)	13(52.0)	11(42.3)	0(0.0)
Заримдаа	29(29.0)	11(42.3)	0(0.0)	0(0.0)	18(69.2)
4	Багш таныг сонсож чаддаг уу				
Сонсдог	75(75.0)	22(84.6)	22(88.0)	17(65.4)	14(53.8)
Сонсдоггүй	3(3.0)	0(0.0)	0(0.0)	2(7.7)	1(3.8)
хааяа	22(22.0)	4(15.4)	3(12.0)	7(26.9)	8(30.8)
5	Багш хичээлийн орон зайн хэм хэмжээг хир баримталдаг вэ				
Баримталдаг	73(73.0)	26(100.0)	21(84.0)	13(50.0)	13(50.0)
Баримталдаггүй	3(3.0)	0(0.0)	0(0.0)	2(7.7)	1(3.8)
Хааяа	24(24.0)	0(0.0)	4(16.0)	11(42.3)	9(34.6)

Иймээс багш оюутнуудтай найрсаг харилцааг бий болгодог уу гэсэн асуумж нь цаашид багш оюутны харилцааг илүү нарийвчлан судлах хэрэгтэйг харуулж байна.

Багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд хэрхэн нөлөөлж буйг “зураг 1”-ээс тодорхой харагдаж байгаа бөгөөд дамжаа өсөх тусам тус нөлөөлөл бага зэрэг буурч буй хэдий ч төгсөлтийн үед дахин өсч байгаа нь анхаарал татаж байна.


Зураг 1. Багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутны сурах хүсэлд нөлөөлдөг байдал



Багш мэдлэгтэй чадвартай байхын зэрэгцээ суралцагчдыг ойлгодог, сурахын төдийгүй сургахын арга ухаанд суралцсан байх шаардлагатай. Энэ чиглэлийн судлаачид багшийн ёс зүйн асуудлыг дорвитой судалж, багшийн харилцааны мөн чанар, үндсэн ойлголтыг онолын түвшинд судлан өнөөгийн багш нарын харилцааны эерэг, сөрөг талыг тодорхойлсноор цаашид багш оюутны харилцааг сайжруулах багшийн харилцаа, арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Харин бидний судалгаагаар багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутнуудын сурах хүсэлд нөлөөлж буй нөлөөлөл (Зураг 2) нь багшаас оюутанд хандах найрсаг харилцаанаас шууд хамааралтай байна.

Зураг 2. Багшаас найрсаг харилцааг хүсдэг байдал



Мөн түүнчлэн багшаас найрсаг харилцааг хүсч байгаа нь оюутнууд нь суралцаж буй дамжаанаас үл хамааран нийтлэг шинжтэй байгаа нь энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагаа ихээхэн чухлыг харуулж буй бөгөөд цаашид тус асуудлыг улам гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна гэж бид үзлээ.

Дүгнэлт:

1. Судалгаанаас үзэхэд багш оюутнуудыг ойлгож сонсож чаддаг, орон зайн хэм хэмжээгээ баримталдаг, оюутнуудыг хувь хүнийх нь хувьд хүндэлдэг, багш нарын мэдлэг эзэмшүүлэх арга зүй нь оюутны сурах хүсэлд нөлөөлдөг зэрэг нь 70-аас дээш хувийг эзэлж байна.

2. Харьцуулсан судалгаагаар I II дамжааны оюутнуудаас III IV дамжааны оюутнууд илүү сөрөг үнэлгээ өгсөн нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь багшийн харилцааны асуудал, арга зүй чадвар, ялангуяа оюутнуудын хөгжил төлөвшилд нөлөөлөх багшийн хувийн зан чанарын талаар анхаарах шаардлагатай байна.

3. Энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагаа сургалтын байгууллагуудад эрчимжүүлэх нь чухал бол судлаачдын хувьд тус асуудлыг улам гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ, шаардлага байна